

## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН  
ТАЙЛАН

/2023 оны I дүгээр улирлын байдлаар/

2023 оны 04 дүгээр сарын 14  
Улаанбаатар хот

**Зорилго:** Гурав. Эдийн засгийн бодлого

**Зорилт:** 3.4. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

**Зорилт:** 3.4.1. Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна.

**Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ:** 3.4.1.1. Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг нэмэгдүүлнэ

**Зорилтот түвшин, үр дүн:** Мэдээллийн төвөөр 6.000 хүн мэдээлэл авсан байна.

**Хэрэгжүүлсэн ажил:** Жуулчны мэдээлэл, сурталчилгааны 7 төвөөр 786, жуулчдад зориулсан 1 арга хэмжээний үеэр мэдээллийн төв ажиллуулж 500 нийт 1786 гадаад дотоодын иргэд, жуулчдад мэдээлэл өгч ажиллав.

**Байнгын үйл ажиллагаа явуулж байгаа Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд**



Нийслэлийн Засаг захиргааны 4-р байранд байрлах Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төв



Төв шууданд байрлах Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төв



Чингис хаан нисэх буудалд байрлах Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төв



ХБНГУ-ын Фрайбург хот дахь Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төв

**Улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байгаа Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд**

Нийслэлийн Аялал жуулчлалын газар, БНСУ-ын “Жэжү Олле” нийгэмлэгтэй 2019 онд “Хамтран ажиллаж санамж бичиг” байгуулан гадаад дотоодын жуулчдад мэдээлэл өгөх зорилготойгоор Монгол Олле мэдээллийн төвүүдийг улирлын чанартайгаар ажиллуулж байна.



Сүхбаатар дүүргийн Сөүлийн гудамжинд байрлах Монгол Олле мэдээллийн төв



Налайх дүүргийн Хонхорт байрлах Монгол Олле мэдээллийн төв



Налайх дүүргийн 6-р хороо Тэрэлжид байрлах Монгол Олле мэдээллийн төв

**Зорилт: 3.4.1.2.** Улаанбаатарын хотын онцлог бүхий брэндийг хөгжүүлж, соёл аялал жуулчлалын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, шинэ аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлнэ.

**Зорилтот түвшин, үр дүн:** Аялал жуулчлалын чиглэлээр 12 үйл ажиллагаа зохион байгуулж, 50.000 хүн оролцсон байна.

**Хэрэгжүүлсэн ажил:**

1. “Улаанбаатарын өвлийн наадам-2023” арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 11,12-ны өдөр Скайрезорт цанын баазад зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Монгол туургатны аварга шалгаруулах, улсын болон хотын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж хот хөдөөгийн 856 хүн, мөсөн сурын тэмцээнд ОХУ-ын Буриад, Тува, Халимаг улсаас 3 багийн 30, БНХАУ-ын ӨМӨЗО-с 1 багийн 10 нийт 40 гаруй тамирчид оролцлоо. Мөн чарга, цана, снөүбоард, параглайдинг, мөсөн хананд авирах, шувуулахуйн танин мэдэхүйн хөтөлбөр, нохой чарга, хоол ундны үйлчилгээг зохион байгуулж, нийт 10.000 гаруй гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон.







2. “Бүргэдийн баяр”-ын арга хэмжээг 2023 оны 03 дугаар сарын 04,05-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн 08 дугаар хороо, Богд хан уулын Жаргалантын аманд байрлах “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт зохион байгууллаа. Арга хэмээний үеэр бүргэдчид үндэсний хувцсаараа гоён гаршуулсан бүргэдээ гарын шуун дээр суулгаж, бүргэдээр ан хийхэд тусгайлан сургасан морьтой жагсаал, хамгийн сайхан үндэсний хувцас, морь, бүргэдийн тоноглолтой шилдэг бүргэдчнийг шалгаруулав. Арга хэмжээг нийт 10.000 хүн үзэж сонирхсон.





3. Францын соёл аялал жуулчлалын өдөрлөгийг 2023 оны 03 дугаар сарын 26-ны өдөр жанжин Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Уг арга хэмжээний үеэр СУИС-ийн оюутнууд хэлээр кармен дуурь, ЕБС-ын 1-р сургуулийн сурагчид Франц хэлээр хүүхдийн дууг олон нийтэд хүргэж, худалдаа үйлчилгээний чиглэлээр 40 аж ахуйн нэгж байгууллага хоол унд, бараа бүтээгдэхүүний танилцуулга хийж оролцов. 5000 хүн үзэж сонирхсон байна.



2023 оны 3 дугаар улирлын байдлаар 3 арга хэмжээ зохион байгуулж нийт 25.856 үзэж, оролцсон байна.

**Зорилтот түвшин, үр дүн:** Улаанбаатар брэнд төсөл арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн байна.

Улаанбаатар хотын брэнд төслийн хүрээнд “Визит Улаанбаатар” лого, уриа үгийг бий болгон батлуулж, Оюуны өмчийн газраас барааны тэмдэгтийн зөвшөөрөл авахаар материал бүрдүүлж байна.





**Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ:** 3.4.1.3. Жуулчдын зорин очих газрын дэд бүтцийг сайжруулж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ

**Зорилтот түвшин, үр дүн:** Шинээр 1 бүтээгдэхүүн нэмэгдүүлсэн байна.

**Хэрэгжүүлсэн ажил:** Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах арга хэмжээний хүрээнд, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш, цогцолборыг байгуулан авто машины зогсоол, гадна хашаа, ариун цэврийн байгууламж, мод бут суулгах ажлыг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/926 дугаар захирамжийн дагуу хийж гүйцэтгэсэн. Үргэлжлүүлэн Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/926 дугаар захирамжийн дагуу он дамжин хийгдэх 2023 оны тохижилтын ажлыг графикайн дагуу 05 дугаар сард төлөвлөөд байна.



**Зорилт:** 3.4.2. Аялал жуулчлалын салбарт инновацийг нэвтрүүлж, гадаад дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.

**Зорилт:** 3.4.2.1. Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны контент бэлтгэж, гадаад, дотоодод түгээн, цахим аялал жуулчлалыг хөгжүүлнэ

**Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ:** Аялал жуулчлалын 2 контент бэлтгэж, 40,000 хүн үзсэн байна.

**Хэрэгжүүлсэн ажил:** Улаанбаатар өвлийн наадам, Бүргэдийн баяр, Францын соёл аялал жуулчлалын өдөр зэрэг арга хэмжээнүүдэд богино хэмжээний 6 минутын видео нэвтрүүлэг хийж инстаграм, фэйсбүүк цахим орчинд байршуулсныг нийт 120,000 хүн үзсэн байна.



**Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ: 3.4.2.2.** Улаанбаатар хотыг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд оролцож, сурталчлан таниулна.

**Зорилтот түвшин, үр дүн:** Олон улсын чанартай 7 үзэсгэлэнд оролцсон байна.

**Хэрэгжүүлсэн ажил:**

1. ХБНГУ-ын Берлин хотод 2023 оны 03 дугаар сарын 4-6-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ай Ти Би-Берлин” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд зочин оролцогчоор оролцсон. Үзэсгэлэнгийн үеэр Улаанбаатар хотыг сурталчлах “Ulaanbaatar Your gateway” сурталчилгааны сэтгүүл 300 ширхгийг тараан, олон улсын байгууллагууд, аж ауй нэгжүүдэд мэдээлэл өгч ажиллав.



2. Монгол-Хятад 2 улсын аялал жуулчлалын зөвлөлийн уулзалт 2023 оны 04 дүгээр сарын 03-06-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотод зохион байгуулагдав. Уулзалтад Нийслэлийн Аялал жуулчлалын газар, тур оператор компани, “Хүннү эйр” компанийн төлөөлөл оролцлоо. Арга хэмээний үеэр Улаанбаатар хотод зохион байгуулагдах олон улсын томоохон арга хэмжээний танилцуулга хийж, Манжуур хотоос тусгай сонирхлын жуулчид хүлээн авах талаар ярилцаж, тур оператор компаниуд, Манжуур хотын тур оператор компаниудтай B2B уулзалт зохион байгуулж, цаашид хамтран ажиллах гэрээ байгуулав.







**Зорилт 3.4.3.** Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

**Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ:** Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**Зорилтот түвшин, үр дүн:** Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ 4-г зохион байгуулсан байна.

**Хэрэгжүүлсэн ажил:** Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр 4 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байна.

**Зорилт: 3.4.3.2.** Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад тавигдах ерөнхий шаардлагад нэмэлт оруулах замаар и-баримтад бүрэн холбож, нийслэл хотын албан татвараас төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ

**Зорилтот түвшин, үр дүн:** Нийслэл хотын албан татвараас нийслэлийн төсөвт 9.000.0 мянган төгрөг төвлөрсөн байна.

**Хэрэгжүүлсэн ажил:** Нийслэл хотын албан татвараас 2023 оны эхний 3 сарын байдлаар 2.348.249.300 төгрөг төвлөрүүлэв.

**Зорилт: 3.4.3.3.** Салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулна

**Зорилтот түвшин, үр дүн:** Сургалтад 450 хүн хамруулсан байна.

**Хэрэгжүүлсэн ажил:**

1. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, бүрдүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Солонгос хэлний аяллын хөтөч-тайлбарлагч” бэлтгэх сургалтыг “Гайд” боловсролын төвтэй хамтран 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаатай зохион байгуулж 12 аяллын хөтөч хамрагдаж байна.

2. Аяллын хөтөч тайлбарлагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Чингис хаан музейтэй хамтран “Чингис хаан музейд тайлбар хийх” эрх олгох сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 21-22-ний өдөр зохион байгуулна. Сургалтад аялал жуулчлалын хөтөч тайлбарлагч 50 хүн хамруулж Чингис хаан музейд 2023 оны турш тайлбар хийх эрхийн үнэмлэх олгоно.

**Зорилт: 3.4.4.1.** “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж, хэрэгжүүлнэ.



**Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ:** “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловс-руулж хэрэгжүүлнэ

**Зорилтот түвшин, үр дүн:** “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловс-руулж хэрэгжүүлсэн байна

**Хэрэгжүүлсэн ажил:** Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 7 зорилтын 77 арга хэмжээ 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар 30%-ийн хэрэгжилттэй байна.

**Зорилт: 3.4.5.1.** Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

**Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ:** Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ

**Зорилтот түвшин, үр дүн:** Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.

**Хэрэгжүүлсэн ажил:** Ковидын дараах нийслэлийн Аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 5 зорилтын 27 арга хэмжээ 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар 30%-ийн хэрэгжилттэй байна.

ТАНИЛЦСАН: ДАРГА

Д.БАТСҮХ

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ГАНБОЛД

НЭГТГЭСЭН: БОДЛОГЫН БАРИМТ  
БИЧГИЙН ТАЙЛАН, СУРГАЛТ  
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХЗУЛ